



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/122

Мандалговь

Г Автотээврийн хөдөлгөөнийг түр
хугацаагаар хориглох тухай

Автотээврийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн ихэнх нутгаар 2018 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөс хур тунадас орж, салхи секундэд 18-20 метр, зарим үед 24-28 метр хүрч хүчтэй цасан болон шороон шуурга шуурч зам даваа хаагдаж, тээврийн хэрэгсэл зорчиход аюултай байдал үүсээд байгаа тул аймгийн хэмжээнд автотээврийн хөдөлгөөнийг түр хугацаагаар хязгаарлаж, олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг хориглосугай.

Хоёр. Автотээврийн хөдөлгөөнийг хязгаарласан талаар аймгийн хэмжээнд сум, байгууллага, иргэд, олон нийтэд мэдээлж, холбогдох мэдээллээр хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга /М.Цогзолмаа/-д үүрэг болгосугай.

Гурав. Аймгийн хэмжээнд автотээврийн хөдөлгөөнийг хязгаарласантай холбоотойгоор хүчтэй цасан болон шороон шуурга зогстол захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа М.Ганбаатар, Автотээврийн дарга Ц.Бямбацогт, Онцгой байдлын газрын дарга, хурандаа Я.Алтанхундага нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0279429